

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙГ БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ ҮЕД ГЭМ ХОР УЧРУУЛАХ ИНСТИТУТЫГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ТУСГАСАН БАЙДАЛ

FOREIGN COUNTRIES' LAW AND ACTS ON AGGRIEVING STATUS TO A CONVICTED CRIMINAL WHILE DETAINING AND ARRESTING



Л.БАТ-ОЧИР

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн ахмад

BAT-OCHIR L.

Senior lecturer of Criminal Law Department, Police Institute, LEU, Ph.D student, Police captain

Товч утга: Монгол Улсын эрүүгийн хууль дахь гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын нэг төрөл болох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах институтыг гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжид хэрхэн хуульчилсан байдлыг харьцуулсан судалсан.

Abstract: Comparison research for Mongolian VS some other countries regulations or law for causing damages to a convicted criminal during a detaining

2002 оны шинэ Эрүүгийн хуульд хүний эрхийг дээдлэх, түүний хэрэгжих баталгааг хангах, эрх зүйн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, төрийн эрх бүхий байгууллагын албан хаагч хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх, эрх ашгаа хамгаалуулах нөхцлийг баталгаажуулхад чиглэгдсэн олон хэм хэмжээ хуульчлагдсаны нэг нь гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын төрөл болох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах тухай заалт юм.

Монгол Улсын эрүүгийн хуульд заасан¹ гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах институтын эрх зүйн зохицуулалт нь онолын түвшинд бүрэн судлагдаагүй, нэг мөр ойлголтонд хүрээгүй, практик хэрэглээнд алдаа дутагдал гарах, харьцангуй бага хэрэглэх, хууль хэрэглэгч субъектийн онолын мэдлэг дутмаг, төрийн тусгай албан хаагчын хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө эрүүгийн хариуцлагад үндэслэлгүйгээр татаж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, улмаар эрүүгийн хуулийн хууль ёсны зарчим алдагдаж төсөөтэй хэрэглэх байдал гарсаар байна. Энэ нь Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах ойлголтын онолын асуудал, эрх зүйн зохицуулалт, түүнийг практикт хэрэглэж байгаа байдал нь учир дутагдалтай, бүрэн судлагдаагүй, маргаантай байдаг учир түүнийг онол,

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002 он 43-р зүйл.

практикийн үүднээс судлах шаардлага зайлшгүй тулгарч байгааг илтгэн харуулж байна. Эрх зүйн шинэчлэлийн бодлого эрчимтэй явагдаж байгаа өнөө үед эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээг зөвхөн Монгол Улс төдийгөөр хязгаарлах нь өрөөсгөл болох тул гадаадын зарим улс орны эрх зүйн дэвшилттэй зохицуулалтын талаар авч үзэх нь онол практикийн чухал ач холбогдолтой тул гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах институтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилтэй уялдуулах, зайлшгүй судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Орчин үед өндөр хөгжилтэй орнуудын эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах тухай ойлголтыг гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын бие даасан нэг төрөл гэж үздэг. Эрх зүйн харилцааны ижил төстэй тулгамдсан асуудлыг гадаадын улс орнуудад хэрхэн шийдвэрлэж байгаа талаархи ололт амжилт болон алдаа дутагдлыг тодруулж, үр дүнг үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд зохистой хэлбэрээр ашиглахад харьцуулсан эрх зүйн судалгаа зайлшгүй шаардлагатай юм. Дээрх зорилгоор гадаадын зарим орнуудын эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах талаар хэрхэн хуульчилсаныг авч үзье.

ОХУ: 1996 онд батлагдсан ОХУ-ын эрүүгийн хуулийн ерөнхий ангийн “Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал” гэсэн 8 дугаар бүлгийн 38 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах асуудлыг бие даасан байдлаар хуульчилжээ. Тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хуулийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах болон тэднийг дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг таслан зогсоох явцад гэм хор учруулсан нь тухайн нөхцөлд өөр аргаар уг этгээдийг баривчлах саатуулах боломжгүй тохиолдолд ба энэ үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хэтрүүлэхгүй бол гэмт хэрэгт тооцохгүй”, мөн 38.2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед тавигдах шаардлагын хэр хэмжээг хэтрүүлсэн гэдэгт гэм хор учруулсан үйлдэл нь баривчлагдаж, саатуулагдаж буй этгээдийн нийгмийн хор аюул хэр хэмжээ, баривчлагдах саатуулагдах үеийн нөхцөл байдлыг илт хэтрүүлсэн байхыг хэлнэ.

Ийм үйлдэл нь зөвхөн санаатайгаар үйлдсэн гэмт хэрэгт тооцогдож эрүүгийн хариуцлага хүлээн² гэж заасан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах ажиллагаанд тавигдах шаардлага буюу хэр хэмжээг хэтрүүлэхгүй байх талаар хуульчилж өгсөнөөрөө онцлог зохицуулалт болжээ.

БНХАУ: Тус улсын эрүүгийн заргын хууль нь социалист хууль ёсны зарчимд үндэслэдэг бөгөөд “ял хийх ба эрүүгийн хариуцлага” гэсэн I дүгээр хэсэгт гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг тодорхой нэр, төрөлгүйгээр хуульчилсан байна.

Тус хуулийн 20 дугаар зүйлд “Улс орон, олон нийтийн ашиг тус, тус хүнээ буюу бусдын биеийн эд хөрөнгийн ба бусад эрхийг яг явагдаж байгаа хууль бус халдлагаас халдлагад учруулахгүйн тулд хууль бусад халдлагыг хориглон зогсоохын тулд авсан үйл ажиллагаа нь хууль бусаар халдагсадад хохирол учруулсан байвал зүй ёсны хамгаалалтанд тооцогдох болохоор эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заагаад зүй ёсны хамгаалалт нь зохих хэмжээнээс илтэд хүнд их хохирол учруулсан байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэвч хөнгөрүүлэн шийтгэх буюу

² Уголовный кодекс. РФ. М., 1996 год

шийтгэлээс хэлтрүүлэх ёстой. Яг үйлдэгдэж байгаа хэрцгийлэх, хүн алах булаан тонох, мэхлэх уулгалах жич, хүний биеийн амар төвшинд хүнд ноцтой хор хохирол учруулсан нь бусад хүчирхийллийн ялт ажиллагаанд хамгаалах ажиллагаа ба хууль бус халдагсадыг шархдуулсан, үхүүлсэн буюу бусад хор уршиг гаргасан байвал хамгаалалт хэтэрсэнд үл тооцогдох болохоор эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэж заасан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах институтын агуулгад нийцэж байна.

АНУ: АНУ нь засаг захиргааны нэгжийн хувьд мужуудад хуваагдах бөгөөд муж бүр өөр өөрийн гэсэн онцлог хуулиудтай байдаг. Тухайлбал, АНУ-ын Техас мужийн Эрүүгийн хуулийн 9 дүгээр хэсгийн 31-р зүйлийн "n" "c" "d" "Онцын шаардлагагүй хүч хэрэглэсэн цагдаагийн ажилтанг "түрэмгийлэгч", баривчлагдаж байгаа этгээдийг "аргагүй хамгаалалтын нөхцөлд байгаа хүн"³ гэж үздэг"⁴ энэ зохицуулалт нь мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах асуудал нь аргагүй хамгаалалтын хэр хэмжээнд нийцсэн байх шаардлагыг агуулж байна.

Голланд улс: Голланд улсын Эрүүгийн хуулийн 44-р зүйлд "Албан тушаалтан (цагдаагийн ажилтан) өөрт нь хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хортойгоор болон хэтрүүлэн ашиглаж бусдад гэм хор учруулбал хууль бус үйлдэлд тооцож хариуцлага хүлээлгэнэ"⁵ гэж хуульчилсан энэ зохицуулалт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулахад нэгэн адил хамаарна Энэ зохицуулалтын онцлог нь гагцхүү албан тушаалтанд хамаарагдах зохицуулалт бөгөөд албан тушаалтан хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ бусдад гэм хор учруулсаныг санаатай гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр байна.

Беларусь Улс: Беларусь Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн "Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал" гэсэн 6 бүлгийн 35-р зүйлд "Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн байгууллагад хүргэх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоохын тулд уг этгээд эсэргүүцэл үзүүлсэн, оргон зайлахыг завдсан, баривчлах саатуулах үед гэм хор учруулсан тухайн нөхцөлд өөр арга хэрэгслээр баривчлах саатуулах боломжгүй үед энэ үйл ажиллагаанд тавигдах үйлдлийг хийсэн үед гэмт хэрэгт тооцохгүй. Мөн 35.2-т "Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед хэтрүүлсэн үйлдлийн нөхцөл нь ижил" мөн 35.3-т "Гэмт этгээдийг баривчлах саатуулах эрхийг хуулиар эрх олгогдсон этгээдээс гадна гэмт хэргийн хохирогч болон бусад этгээд эдэлнэ" гэж хуульчилсан нь уг арга хэмжээг хэрэгжүүлэх субъект, тавигдах шаардлага нөхцөлийг тусгасан зохицуулалт болжээ.

Молдав улс: 2002 онд батлагдсан тус улсын эрүүгийн хуулийн ерөнхий ангийн "Гэмт хэргийн эрүүгийн шинжийг арилгах нөхцөл байдал" гэсэн 3 дугаар бүлгийн 37-р зүйлд "Гэмт этгээдийг баривчлах" заалтыг оруулсан байна.

37 дугаар зүйлийн 37.1 дахь хэсэгт "Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах хууль хяналтын байгууллагад хүргэхийн тулд эрүүгийн хуульд заасан үйлдлийг гэм хор учруулах замаар хийснийг гэмт хэрэгт тооцохгүй" гэж хуульчилсан нь манай улсын Эрүүгийн хуульд заасан хэм хэмжээтэй зарим талаараа төсөөтэй

³ С. Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. (I боть гэмт хэргийн сургааль). УБ., 2009 704 дахь тал

⁴ Samada J. Criminal law. Paul., Minn., 1993. P. 265; Уголовное право зарубежных стран. М., 2003. 161 дэх тал

⁵ Уголовный кодекс Голландии. СПб. 2001. 174 дэх тал

зохицуулалт болсон байна. Учир нь тус улсын эрүүгийн хуульд заасан дээрх хэм хэмжээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах ажиллагаанд тавигдах шаардлагыг хуульчлаагүй байна. Харин манай улсын Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гадна оргосон ялтанг баривчлахдаа гэм хор учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар заасан бол Молдав улсын эрүүгийн хуульд оргосон ялтан гэсэн ойлголтыг хуульчлаагүй байна.

Польш улс: 1997 онд батлагдсан тус улсын эрүүгийн хуулийн⁶ ерөнхий ангийн 3-р бүлэгт “Эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх нөхцөл байдал”-уудыг хуульчилсан бөгөөд энэ бүлгийн 25-р зүйлд. Аргагүй хамгаалалт, 26-р зүйлд “Гарцаагүй байдал”, 27-р зүйлд “Туршилт хийх” (эрсдэл хийх) зэрэг нөхцөл байдлуудыг хуульчилсан нь манай 1987 оны шинэчилэн найруулсан эрүүгийн хуультай төстэй болжээ. Учир нь тус улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах институтыг бие даасан хэлбэрээр хуульчлаагүй бөгөөд энэ нөхцөл байдлыг аргагүй хамгаалалтын нөхцөл байдалтай адилтган үзсэн байна.

Болгар улс: Болгар улсын эрүүгийн хуулийн⁷ ерөнхий ангийн 2-р бүлэгт гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын нийтлэг үндэслэлийг тусгасан бөгөөд 12 дугаар зүйлийн а-д “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг саатуулах үндэслэл” “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хуулийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах болон тэднийг дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг таслан зогсоох явцад гэм хор учруулсан нь тухайн нөхцөлд өөр аргаар уг этгээдийг баривчлах саатуулах боломжгүй тохиолдолд ба энэ үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хэтрүүлэхгүй бол гэмт хэрэгт тооцохгүй. Мөн 12 дугаар зүйлийн а-2-д “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед тавигдах шаардлагын хэр хэмжээг хэтрүүлсэн гэдэгт гэм хор учруулсан үйлдэл нь баривчлагдаж саатуулагдаж буй этгээдийн нийгмийн хор аюул хэр хэмжээ, баривчлагдах саатуулагдах үеийн нөхцөл байдлыг илт хэтрүүлсэн байхыг ойлгоно гэж хуульчилсан нь оновчтой зохицуулалт болжээ.

Япон улс: Япон Улсын эрүүгийн хууль нь 1907 онд батлагдаж өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж иржээ. Тус хуулийн нийтлэг үндэслэлийн 1 дэх хэсэг 7-р бүлэгт “Гэмт хэргийн бүрэлдэхүүн үүсэхгүй нөхцөл байдал”⁸ гэж гэмт хэрэг болохгүй нөхцөл байдлуудыг хуульчилсан байна. Гэмт хэргийн бүрэлдэхүүн үүсэхгүй нөхцөл байдлыг гэмт хэргийн хор аюулаар нь 1) Хууль ёсны хамгаалалт, 2) Гарцаагүй байдал гэж ангилаад түүний улмаас учрах гэм хорын талаар тусгаагүй байгаагаас гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах асуудлын талаар тусгайлан зохицуулаагүй байна.

Солонгос улс: Эрүүгийн хуулийн Нийтлэг үндэслэл гэсэн 1 дүгээр хэсгийн “Гэмт хэрэг” гэсэн 2-р бүлэгт гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг хуульчилж өгчээ. Үүнд:

1. Хууль ёсны үйл ажиллагаа (20-р зүйл)
2. Өөрийгөө хамгаалах (21-р зүйл)
3. Гарцаагүй байдал зайлшгүй шаардлага (22-р зүйл)

4. Хохирогчийн зөвшөөрөл тусгайлан зааж өгөөгүй энэ үйлдэл нь хууль ёсны үйлдэлдээ ордог (Хуулиар зөвшөөрсөн үйлдэл).

Солонгос Улсын эрүүгийн хуульд тусгагдсан нөхцөл байдлуудад дүн шинжилгээ хийж үзэхэд бусад орнууд болон манай улсын эрүүгийн хуульд төдийлөн

⁶ Уголовный кодекс Республика Польша Минск 1997 г.

⁷ Уголовный кодекс Народной Республика Болгария 1970 г.

⁸ Уголовный кодекс.Законодательство зарубежных стран Японии 2001 г.

тусгагдаагүй “хохирогчийн зөвшөөрөл” тухай зохицуулалтыг тусгажээ. Харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах институтийг хуульчлаагүй байна.

Белги улс: Эрүүгийн хуулийн I хэсэг “Гэмт хэрэг ялын тухай нийтлэг үндэслэл” гэсэн 8-р бүлэгт “Эрүүгийн хариуцлага ялаас чөлөөлөх үндэслэл” 70 дугаар зүйлд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын төрлийг нь заахгүйгээр ерөнхий утгаар нь хуульчилсан. Үүнд “Хуулиар зөвшөөрсөн буюу төрийн байгууллагын тушаалаар хийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй гэжээ. Энэхүү зохицуулалтаас үзэхэд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг төрөл бүрээр нь хуульчлаж өгөөгүй нь нэг талаас энэ асуудлыг өргөн хүрээнд хэргийн нөхцөл байдлаас нь хамааруулж гэмт хэрэгт тооцохгүй байх хүрээнд авч үзсэн гэж үзэх талтай байна.

Швейцари улс: Тус улсын эрүүгийн хуулийн “Гэмт хэрэг” гэсэн 2 дугаар бүлгийн 32-34 дүгээр зүйлд “Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх” нөхцөл байдлуудыг хуульчилсан нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

1. Хуулиар зөвшөөрсөн албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх (32 дугаар зүйл)

2. Аргагүй хамгаалалт (33-р зүйл)

3. Гарцаагүй байдал (34-р зүйл) гэжээ. Гэмт этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах асуудал нь тус хуулийн 32 дугаар зүйлд заасан “Хуулиар хүлээн зөвшөөрсөн албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх”⁹ гэсэн заалтад хамааралтай юм.

32 дугаар зүйлд зааснаар хуулиар зөвшөөрсөн албаны болон мэргэжлийн үйл ажиллагаагаар хэрэгжүүлсэн үйлдэл нь хуульд гэмт хэрэг гэж хуульчлагдаагүй хүлээн зөвшөөрөгдсөн, ял оногдуулна гэж заагаагүй бол гэмт хэрэг тооцохгүй байх агуулгатай зохицуулалт гэж үзэж болохоор байна.

Турк улс: 1926 онд батлагдсан Турк улсын эрүүгийн хуулийн Нийтлэг үндэслэл гэсэн I хэсгийн 4 дүгээр бүлэгт “Эрүүгийн хариуцлага ба ялыг үгүйсгэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдал”-уудыг хуульчилсан нь гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд гэж үзэж болохоор байна.

Тус хуулийн 49-р зүйлд “Ялыг үгүйсгэх нөхцөл байдал”-ыг нийтлэг байдлаар нь хуульчилжээ. 49 дүгээр зүйлд дор дурьдсан үйлдэлд эрүүгийн ял хүлээлгэж болохгүй.

Үүнд:

1. Хуулийн заалтыг хэрэгжүүлсэн эсвэл төрийн байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн бөгөөд энэ нь түүний албан үүрэгт нь шууд хамаарч байвал.

2. Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, нэр хүнд, халдашгүй байдалд халдсан хууль бус халдлагаас хамгаалахын тулд зайлшгүй үйлдэл хийсэн.

3. Өөрийн болон бусдын аюулгүй байдал бодитой ноцтой хор уршиг учруулах нөхцөлд түүнийг зайлуулахын тулд зайлшгүй хийсэн үйлдэлд эрүүгийн ял хүлээлгэхгүй гэж тус тус заажээ.

Дээрх зохицуулалтаас үзэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах асуудлыг 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт зааснаар ойлгож болохоор байна.

Эцэст нь дүгнэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм

⁹ Уголовный кодекс. Законодательство зарубежных стран. Швейцари. 2001 г.

хор учруулах институт нь гадаадын ихэнх улсуудын эрүүгийн хуульд ямар нэгэн хэмжээгээр хуульчлагджээ. Уг хэм хэмжээг хуульчилсан байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах 3 нийтлэг хандлага ажиглагдаж байна.

Үүнд:

а) бие даасан хэлбэрээр;

б) аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын агуулгад багтаах хэлбэрээр;

в) гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл гэсэн ерөнхий зохицуулалтаар хуульчлагдсан бөгөөд гагцхүү түүний хэр хэмжээ, хэрэгжүүлэх зорилго субъектын онцлогоороо харилцан адилгүй байгаа нь харьцуулсан судалгааны дүнгээс харагдаж байна.